



MOORE

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

НӨМӨР КРЕДИТ ACCET ТЗК ХХК

2023 оны 12 дугаар сарын 31 -ний өдрөөр тасалбар болгосон
санхүүгийн тайлангийн аудит

**НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
Аудитлагдсан санхүүгийн тайлан
2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон**

Агуулга

Гүйцэтгэх удирдлагын хариуцлагын мэдэгдэл	2
Байгууллагын мэдээлэл	3
Хараат бус аудиторын дүгнэлт	4-8
Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	9
Санхүүгийн байдлын тайлан	10
Өмчийн өөрчлөлтийн тайлан	11
Мөнгөн гүйлгээний тайлан	12
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	13-36

**НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
2023 оны 12 сарын 31-ний Өдреөр Тасалбар Болгосон Санхүүгийн Тайлан
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК-ийн удирдлага бид санхүүгийн тайлангаа бэлтгэх явцад Хараат бус аудиторын тайлан дахь Санхүүгийн тайлангийн аудитад удирдлагын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрч байна гэдгийг мэдэгдэж байна.

Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлакналын Олон Улсын Стандартад нийцүүлэн, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн удирдлагаас 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдреөр тасалбар болгосон санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

Н. БААСАНХҮҮ
И. Баасанхүү
УЛААНБААТАР ХОТ
НӨМӨР КРЕДИТ
АССЕТ ТЗК
ХХК
ТӨЛӨӨЛӨӨ - УДИРДЛАЧАА ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Огноо: *2024.01.05*

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Байгууллагын мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр

Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК нь 2022 оны 04 сарын 29-ний өдрийн үүсгэн байгуулагчдын шийдвэрийн дагуу Монгол улсын хуулийн хүрээнд үүсгэн байгуулагдсан.

Компани нь Монгол Улсын Бүртгэлийн Газарт 2022 оны 05 сарын 03-ний өдөр бүртгэгдсэн.

Байгууллагын регистрийн дугаар 6862705

Монгол улсын хуулийн этгээд Нөмөр Кредит ББСБ ХХК нь саналын эрхтэй энгийн хувьцааг 100 хувь эзэмшдэг.

ТУЗ-ийн дарга Н. Баасанхүү

ТУЗ-ийн хараат бус гишүүн Б. Рэнцэнханд

ТУЗ-ийн хараат бус гишүүн Б. Эрдэнэжаргал

Хувьцаа эзэмшигчид

ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл

Гүйцэтгэх удирдлага

Гүйцэтгэх захирал Монгол улсын иргэн Жүнгууз овогтой Баатарсүрэн

Бүртгэлтэй хаяг

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 45 байр, 806 тоот

Аудиторууд

“Мүүрь Аудит” ХХК

Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчид

Хараат бус аудиторын дүгнэлт

Немер Кредит Ассет ТЗК ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бид, Немер Кредит Ассет ТЗК ХХК-ийн (цаашид Компани гэх) 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аudit хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Компанийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан журмын дагуу бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулагдсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад нөлөө бүхий асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд дараах асуудлуудыг авч үзсэн ба уг асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй.

Компанийн үйл ажиллагааны цикл нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авсан зээлийн багцын эргэн төлөлтөөс бий болох мөнгөн урсгалаар тус үнэт цаасны үүргийн гүйцэтгэлийг хангуулах юм.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу шилжүүлэн авсан зээлийн багц нь СТОУС-ын дагуу хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгө юм. Хөрөнгийн багц дахь зээлүүд нь 72 сар хүртэлх хугацаатай байх боловч эдгээр зээлүүд нь Компанийн үйл ажиллагааны нэг циклийн дотор мөнгөн урсгалыг цуглуваж, үнэт цаасны үүргийн гүйцэтгэлийг хангах зорилготой бөгөөд хугацаанаас өмнө хөрөнгийн багцаас хасагдаж болох учир эргэлтийн хөрөнгөөр ангилан бүртгэсэн байна.

Компанийн үйл ажиллагааны нэг циклийн хүрээнд үр ашигт хүү болон нэрлэсэн хүүгийн түвшин ашиглаж тооцсон зээлийн багцын дансны үнэ, хүүгийн орлого нь материаллаг зөрүү үүсээгүй болно.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс анgid эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад байдаг. Ул үндэслэлтэй нотолгоо нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг цаг ямагт илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсэж болох ба дангаараа нийлээд материаллаг болж эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримталдаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залиланд хувалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан няглан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, няглан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Няглан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцаж, хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг.

Мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлантуеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг.

Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үздэг учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Аудитын дүгнэлт нь бусад мэдээллийг хамруулаагүй ба бид үүнтэй холбоотой ямар нэгэн баталгаажуулалт хийгээгүй болно. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бусад мэдээллийг уншиж танилцан, бусад мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан аудиторын мэдлэгээс материаллаг зөрүүтэй эсэхийг тодорхойлж, хэрэв бусад мэдээлэл нь материаллаг зөрүүтэй бол бид энэ тухай тайлагнах үүрэгтэй.

Бид бусад мэдээлэлд Үнэт цаасны танилцуулга болон Хөрөнгө Итгэмжлэн Удирдагчийн тайланг хамруулан үзсэн ба Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой эдгээр мэдээллийн талаар тайлагнах зүйлс байхгүй.

Бусад асуудал

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Нөмөр Кредит Ассет ТЗК ХХК-ийн Монгол улсын Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасан хувьцаа эзэмшигчдэд

зориулан гаргасан бөгөөд бусад этгээдэд зориулагдаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Хаяг: Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр,
Centrum төв, 7 давхар 701 тоот. **Утас:** 976-70150003, И-мэйл: info@moore-mongolia.mn

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

	Тод	Aудитлагдсан	Aудитлагдсан
		2023.12.31 мян.төг	2022.12.31 мян.төг
Хүүгийн орлого	6	2,850,566	648,690
Хүүгийн зардал	7	(1,579,379)	(354,795)
Нийт ашиг		1,271,187	293,895
Үйл ажиллагааны зардал	8	(516,434)	(494,050)
Бусад зардал	9	(40)	(42,338)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		754,713	(242,493)
Орлогын татварын зардал	10	(75,471)	-
Тайлант жилийн ашиг (алдагдал)		679,242	(242,493)
Бусад дэлгэрэнгүй ашиг алдагдал, Нийт дэлгэрэнгүй ашиг (алдагдал)			(242,493)



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн
салшгүй хэсэг болно.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
Санхүүгийн байдлын тайлан
2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

	Тод	Аудитлагдсан 2023.12.31 мян.төг	Аудитлагдсан 2022.12.31 мян.төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Бусад авлага	11	425,124	534,980
Хүүгийн авлага	12	149,741	264,956
Санхүүгийн хөрөнгө	13	5,064,259	9,275,254
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	14	9,305	38,112
Нийт эргэлтийн хөрөнгө		5,648,429	10,113,302
НИЙТ ХӨРӨНГӨ		5,648,429	10,113,302
Өмч			
Хувьцаат капитал	15	1,000	1,000
Хуримтлагдсан ашиг	16	436,749	(242,493)
Нийт өмч		437,749	(241,493)
Өр төлбөр			
Үрт хугацаат өр төлбөр			
Санхүүгийн өр төлбөр	17	-	5,000,000
Нийт үрт хугацаат өр төлбөр		-	5,000,000
Богино хугацаат өр төлбөр			
Бусад өглөг	19	16,000	-
Орлогын татварын өр	19	17,283	-
Хүүгийн өглөг	18	177,397	354,795
Санхүүгийн өр төлбөр	17	5,000,000	5,000,000
Нийт богино хугацаат өр төлбөр		5,210,680	5,354,795
Нийт өр төлбөр		5,210,680	10,354,795
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		5,648,429	10,113,302



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн
салшгүй хэсэг болно.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
Өмчийн өөрчлөлтийн тайлан
2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

Тод	Хувьцаат капитал	Хуриимтлагдсан ашиг/(алдагдал)	Нийт мян.төг
	мян.төг	мян.төг	
2022 оны 04-р сарын 29-ний үлдэгдэл	1,000	-	1,000
Тайлант жилийн ашиг (алдагдал)	16	-	(242,493) (242,493)
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000	(242,493)	(241,493)
Тайлант жилийн ашиг (алдагдал)	16	679,242	679,242
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000	436,749	437,749



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн
салшгүй хэсэг болно.

**НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
Мөнгөн гүйлгээний тайлан
2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон**

	Тод	Аудитлагдсан	Аудитлагдсан
		2023.12.31	2022.12.31
		мян.төг	мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Татварын өмнөх ашиг		679,242	(242,493)
Тохируулга:			
Хүүгийн зардал	7	1,579,379	354,795
Ажлын капиталын өөрчлөлт:			
Санхүүгийн хөрөнгийн (өсөлт)/бууралт		4,210,995	(9,275,254)
Бусад авлагын (өсөлт) /бууралт		225,071	(799,936)
Бусад өглөгийн өсөлт /(бууралт)		(144,115)	-
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн гүйлгээ		6,550,572	(9,962,888)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Өрийн бичиг гаргаснаас хүлээн авсан		-	10,000,000
Өрийн бичгийн төлбөрт төлсөн		(5,000,000)	-
Өрийн бичгийн хүү		(1,579,379)	-
Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулагдсан мөнгөн гүйлгээ		(6,579,379)	10,000,000
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)		28,807	37,112
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		38,112	1,000
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		9,305	38,112



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
Санхүүгийн тайлангийн тодруулга
2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон**

1. Ерөнхий мэдээлэл

Немөр Кредит Ассет ТЗК ХХК нь 2022 оны 04 сарын 29-ний өдөр үүсгэн байгуулагчийн шийдвэрээр Монгол улсын хуулийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Компани нь 2022 оны 05 сарын 03-ны өдөр Монгол Улсын Бүртгэлийн Газарт бүртгэгдэж 9011839181 дугаартай Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. Компанийн регистрийн дугаар 6862705.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа бөгөөд 2022 оны 08 сарын 10-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос ТЗ 315/46 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан.

Нийт саналын эрхтэй энгийн хувьцааг Монгол улсын хуулийн этгээд Немөр Кредит ББСБ ХХК (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч) 100% эзэмшиж байна.

Компанийн албан ёсны бүртгэлтэй хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот, Монгол Улс, Улаанбаатар хот, 2-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 45 байр, 806 тоот. Компани нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргач аж ахуйн нэгж юм.

2. Үйл ажиллагааны тасралтгүй зарчим

Компани нь 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 679,242 (2022: (242,493)) мян.төгрөгийн цэвэр ашигтай, 5,210,680 (2022: 5,354,795) мян.төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй, 5,648,429 (2022: 10,113,302) мян.төгрөгийн эргэлтийн хөрөнгетэй ажилласан байна.

Компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу зөвхөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд үнэт цаасны өр төлбөр бүрэн төлөгдсөн тохиолдолд татан буугдахаар хуульчилсан байна.

Тус хуульд Компанийн тасралтгүй зарчим алдагдаж, татан буугдах нөхцөлийг дараах байдлаар заасан байна:

- Үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;
- Хөрөнгийн багцыг үүсгэн байгуулагч буцаан худалдан авсан;
- Үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаас эзэмшигчдийн гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан

Тайлант хугацаанд Компанийн хувьд тасралтгүй зарчим алдагдах нөхцөл байдал үүсээгүй бөгөөд үйл ажиллагаа хэвийн, хуулийн хүрээнд явагдаж байна.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд

Энэхүү санхүүгийн тайланд агуулагдсан доорх нэр томъёог дараах байдлаар ойлгоно:

БДОБҮЦ- Бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнээр хэмжигдсэн

ААБҮЦ- Ашиг алдагдал болох бодит үнэ цэнээр хэмжигдсэн

БДО- Бусад дэлгэрэнгүй орлого

3.1 Тайлан бэлтгэх үндэслэл

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо ("НББОУСХ")-ноос гаргаж, мөрдүүлсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС") болон СТОУС-ын Тайлбарын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн байна. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан журам, Монгол Улсын Сангийн яамнаас батлагдсан заавар журмыг мөн даган мөрдсөн болно.

Санхүүгийн тайлангууд нь түүхэн өртөгт суурилж бэлтгэгдсэн бөгөөд тодорхой санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгүүд нь холбогдох стандартын шаардлагуудын дагуу илэрхийлэгдсэн.

Компанийн тайлагналын болон үйл ажиллагааны валют нь Монгол Улсын төгрөг юм. Энэ санхүүгийн тайлан нь төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд мянган төгрөгөөр (мян.төг) нарийвчлагдсан болно.

3.2 Шинэ болон нэмэлт өөрчлөлт бүхий стандартууд болон тайлбарууд

Дараах стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс болон дараагийн тайлант үеүдэд хүчин төгөлдөр мөрдөгдөнө:

- СТОУС 17 Даатгалын гэрээ
- НББОУС 1 болон СТОУС практикийн мэдэгдэл 2 Нэмэлт өөрчлөлт
- НББОУС 8 НББ-н тооцоолол нэмэлт өөрчлөлт
- НББОУС 12 Нэг удаагийн ажил гүйлгээнээс үүсч буй хөрөнгө, өр төлбөрийн хойшлогдсон татварын асуудал

Дээрх стандартуудын өөрчлөлтүүдээс Компанид хамааралтай хэсгүүдийг дэлгэрүүлбэл дараах байдалтай байна:

НББОУС 1 болон СТОУС практикийн мэдэгдэл 2 Нэмэлт өөрчлөлт- Бүртгэлийн бодлогын тодруулга-Энэхүү нэмэлт өөрчлөлт нь дараах зүйлсийг өөрчилсөн:

- СТОУС 7, Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд санхүүгийн хэрэгслүүдийн хэмжилтийн суурь нь материаллаг байна,
- НББОУС 1, Аж ахуйн нэгжүүдийг гол бүртгэлийн бодлогоос илүүтэйгээр материаллаг бүртгэлийн бодлогыг тодруулахыг шаардаж байгаа,

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

3.2 Шинэ болон нэмэлт өөрчлөлт бүхий стандартууд болон тайлбарууд

(Үргэлжлэл)

- НББОУС 34, Материаллаг бүртгэлийн бодлогыг иж бүрэн сет санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн болгож тодорхойлох,
- СТОУС практикийн мэдэгдэл 2, материаллаг бүртгэлийн бодлогын тодруулга болон түүнийг хэрхэн тодорхойлох талаар удирдамжаар хангасан.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийг ирээдүйд гүйцээн мөрдөх горимын дагуу ашиглана.

НББОУС 8 НББ-н тооцоолол нэмэлт өөрчлөлт- Аж ахуйн нэгж байгууллагуудыг НББ-н тооцоолол болон НББ-н бодлогын өөрчлөлтийг хэрхэн ялгахыг тодорхой болгохыг шаардсан. Мөн санхүүгийн тайланд хэмжилтийн тодорхойгүй байдлаас үүдэлтэй мөнгөн дүнг тодорхой тодруулах талаар нэмж өөрчилсөн.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийг ирээдүйд гүйцээн мөрдөх горимын дагуу ашиглана.

3.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбарууд

Дараах батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд Компанийн санхүүгийн тайланд нөлөөлж болзошгүй байгаа бөгөөд эдгээр стандарт болон тайлбаруудыг хамааралтай тохиолдолд 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс цааш хүчин төгөлдөр хугацаанаас мөрдөх болно:

- **НББОУС 1 Нэмэлт өөрчлөлт-** Эргэлтийн болон эргэлтийн бус өр төлбөрийн ангилал
- **НББОУС 1 Нэмэлт өөрчлөлт-** Эргэлтийн бус өр төлбөрийн гэрээний нөхцөлүүд (ковинантс)
- **НББОУС 7 ба СТОУС 7-** Нийлүүлэгчийн санхүүжүүлэх нөхцөлтэй гэрээ
- **СТОУС 16 Нэмэлт өөрчлөлт-** Борлуулаад буцаан түрээслэх үеийн түрээсийн өр төлбөр
- **СТОУС 10 ба НББОУС 28 Нэмэлт өөрчлөлт-** Хөрөнгө оруулагч ба хараат компани, хамтарсан үйлдвэр хоорондын хөрөнгийн борлуулалт ба хандивын ажил гүйлгээ

3.4 Ашигласан нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын хураангуй

3.4.1 Сегментийн мэдээлэл

Үйл ажиллагааны сегмент гэдэг нь аж ахуйн нэгжийн дараах шинж чанаруудыг агуулсан бүрэлдэхүүн юм:

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

3.4.1 Сегментийн мэдээлэл (Үргэлжлэл)

Орлого олж, зардал гаргадаг (аж ахуйн нэгжийн доторх бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй хийсэн орлого, зардлын ажил гүйлгээ мөн багтана) бизнесийн үйл ажиллагаа;

- Сегментэд нөөц хуваарилах, гүйцэтгэлийг үнэлэхтэй холбоотой шийдвэр гаргах зорилгоор аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны шийдвэр гаргагч ахлах ажилтны зүгээс үйл ажиллагааны үр дүнг нь тогтмол хянаж байдаг;
- Тусдаа санхүүгийн мэдээлэл бэлтгэх боломжтой.

Дээрх шаардлагыг хангасан сегментүүдийн хувьд уг Компани сегмент бүрээр ашиг, алдагдал, хөрөнгө, өр төлбөрийг тодруулах шаардлагатай.

Компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах гэсэн үйл ажиллагааны ганц сегменттэй ба ганц үүрэг гүйцэтгүүлэгчтэй тул санхүүгийн тайлан нь энэхүү сегментийн дагуу бэлтгэгдсэн болно.

3.4.2 Хүү, түүнтэй адилтгах орлого

Хүүгийн орлого нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-гээр худалдан авсан зээлийн багцын (Хөрөнгийн багц) хүүгийн орлогоос бүрдэнэ.

Хөрөнгийн багц дахь зээлүүд нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан "Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам"-ын дагуу тодорхой шаардлагыг хангахгүй болсон нөхцөлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдаж, уг зээлийн хүүг хуримтлуулж бүртгэхийг зогсоож, өмнө нь хуримтлуулсан хүүг буцаана.

Нэмэгдүүлсэн хүүгийн орлогыг төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн үнийн дүнгээс Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгч нарын хооронд байгуулсан гэрээнд заасан хувийн дагуу тооцдог.

Компанийн үйл ажиллагааны цикл нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авсан зээлийн багцын эргэн төлөлтөөс бий болох мөнгөн урсгалаар тус үнэт цаасны үргийн гүйцэтгэлийг хангуулах юм.

Компанийн үйл ажиллагааны нэг цикл нь богино хугацаатай учир Үр ашигт хүүгийн түвшин ба нэрлэсэн хүүгийн түвшинг ойролцоо гэж үзээд хүүгийн орлогын тооцоололд нэрлэсэн хүүг ашиглаж ашиг алдагдал болон орлогын дэлгэрэнгүй тайланд аккруэл сууриар бүртгэдэг.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

3.4.3 Татварын зардал

Татварын зардал нь одоогийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэнэ. Одоогийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох тайлангийн өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцогдоно. Тайлант жилийн татвар ногдох орлого гэдэг нь тайлант жилийн үр дүнг татварын хуулийн дагуу зөвшөөрөгдхөн болон үл зөвшөөрөгдхөн зүйлсээр тохируулсан дүн юм.

Одоогийн болон хойшлогдсон татвар нь бусад дэлгэрэнгүй орлогоор эсвэл өмчөөр хүлээн зөвшөөрөгдхөн зүйлстэй хамааралтайгаас бусад тохиолдолд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгднө. Эдгээр зүйлстэй холбоотой татвар нь бусад дэлгэрэнгүй орлогоор эсвэл өмчөөр хүлээн зөвшөөрөгднө.

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэ ба татварын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үссэн, ирээдүйд төлөгдхөн эсвэл буцаан авахаар хүлээгдэж буй өр төлбөрийн аргыг ашиглан бүртгэсэн татвар юм.

Хойшлогдсон татварын өр төлбөрийг ихэвчлэн бүх татвар ногдох түр зөрүүнд ногдох дүнгээр хүлээн зөвшөөрдөг бол хойшлогдсон татварын хөрөнгийг хасагдах түр зөрүүг ашиглахын тулд татварын зорилгоор ашигтай байх магадлалтай тохиолдолд хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгө өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үссэн түр зөрүү нь бүртгэлийн болон татварын ашигт нөлөөлөхгүй бол хойшлогдсон татварын хөрөнгө өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй (бизнесийн нэгдлээс бусад тохиолдолд).

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант үе бүрд хянаж үзэх бөгөөд тухайн хөрөнгийг ашиглах хангалттай татварын ашигтай ажиллах магадлалгүй тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийн дүнг бууруулна. Газар болон дахин үнэлсэн хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн хойшлогдсон татварыг борлуулах үед нөхөгднө гэж үзнэ.

Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.

3.4.4 Санхүүгийн хөрөнгө

Хүлээн зөвшөөрөлт ба данснаас хасалт

Компани тухайн санхүүгийн хэрэгслийн гэрээний нэг оролцогч тал болсон үед дерватив хэрэгслээс бусад санхүүгийн хөрөнгийг Компанийн санхүүгийн байдлын тайланд тусгадаг.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

3.4.4 Санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)

Худалдааны авлагаас бусад санхүүгийн хэрэгслүүд нь анх худалдан авалтын өртөгтэй ойролцоо байх бодит үнэ цэнээр хэмжигдэх ба дараа үед ашиг алдагдал болох бодит үнэ цэнээр хэмжигдэггүй санхүүгийн хэрэгслүүдийн хувьд ажил гүйлгээний зардлыг мөн анхны өртөгт багтаадаг.

Санхүүгийн хөрөнгүүдийг дараах нөхцөлүүд биелсэн үед үл хүлээн зөвшөөрне:

- Санхүүгийн хөрөнгөес орж ирэх/гадагшлах мөнгөн урсгалыг хүлээн авах гэрээний эрх дуусгавар болсон; эсвэл
- Орж ирэх мөнгөн урсгалыг хүлээн авах гэрээний эрх шилжсэн болон уг хөрөнгийн эрсдэл, өгөөж нь бусдад шилжсэн.

Үл хүлээн зөвшөөрөлтийн үед Компани дансны үнэ болон хүлээн авсан мөнгөний зөрүүг хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн ангилал болон хэмжилт

Санхүүгийн хөрөнгийн хэмжилт болон ангилал нь тэдгээрийг эзэмшиж буй бизнесийн зорилго болон мөнгөн урсгалын шинж чанааран дараах байдалтай байна:

i. Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгүүд

Гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах зорилгоор эзэмшиж буй бизнесийн загвар бүхий санхүүгийн хөрөнгүүдийг энэ ангилалд хамруулна. Гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болдог. Хөрөнгийн багц дахь зээлүүд, бусад авлага зэрэг хэрэгслүүдийг энэ ангилалд авч үзнэ. Хүүг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцох бөгөөд санхүүгийн орлогоор ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Аливаа үнэ цэний бууралт нь ашиг алдагдалд тусдаа мөрөнд толилуулагдана.

ii. Бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн (БДОБҮЦ);

Компани санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах болон мөн худалдах зорилгоор эзэмшиж байгаа бол эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэж өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнана. Мөн гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болдог.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

3.4.4 Санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)

Хүүгийн орлогыг мөн үр ашигт хүүгийн аргаар тооцоолж санхүүгийн орлогоор ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэний бууралтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөх бөгөөд бодит үнэ цэний олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Үл хүлээн зөвшөөрөлтийн үед бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн олз, гарзыг ашиг алдагдалд хүлээн зөвшөөрч бусад олз, гарзаар толилуулна.

Компанид тайлант оны эцэст БДОБҮЦ-р хэмжигдэх санхүүгийн хөрөнгө байгаагүй.

iii. Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн (ААБҮЦ)

Дээрх шалгууруудыг хангахгүй байгаа санхүүгийн хөрөнгүүдийг ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө гэх бөгөөд бодит үнэ цэний өөрчлөлтийг бусад олз, гарзаар ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого нь материаллаг бус буюу санхүүгийн хөрөнгийн хугацаа нь 12 сараас ихгүй тохиолдолд хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгийн хувиар хүлээн зөвшөөрнө.

Компанид тайлант хугацааны эцэст ААБҮЦ-р хэмжигдэх санхүүгийн хөрөнгө байгаагүй.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралт

Санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэний бууралтын гарзыг хүлээгдэж буй гарзын загвар (Expected credit loss model) ашиглан тооцоолно. Энэ нь хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн болон БДОБҮЦ-рх өрийн үнэт цаасанд оруулсан санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хамаарлтай.

Энэ загварын дагуу, хүлээгдэж буй гарзыг санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсөн цэгээс тооцоолох бөгөөд тухайн хөрөнгийн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өөрчлөлт орсон эсэхээс үнэ цэний бууралтыг тооцох аргачлал хамаарна.

Бусад санхүүгийн хөрөнгүүдийн хувьд зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц ёссен болон үнэ цэн нь буурсан гэсэн бодит нотолгоо байгаагаас бусад тохиолдолд 12 сарын хугацааны зээлийн алдагдлын аргыг ашиглана (Тодруулга 4.3).

3.4.5 Санхүүгийн өр төлбөр

Хүлээн зөвшөөрөлт ба данснаас хасалт

Компани нь гэрээний оролцогч тал болсон тохиолдолд санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

3.4.5 Санхүүгийн өр төлбөр (Үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбериийн гэрээний үүрэг барагдсан, цуцлагдсан, хугацаа нь дууссан эсвэл бусад стандартын шаардлагыг хангасан үед санхүүгийн өр төлбериийг үл хүлээн зөвшөөрнө. Үл хүлээн зөвшөөрөлтийн үед дансны үнэ болон төлсөн дүн хоёрын зөрүүнээс үүссэн олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Одоо байгаа санхүүгийн өр төлберийн (Зээл болон зээллэг) гэрээний ихэнх нөхцөлүүд өөрчлөгдсөн бол хуучин өр төлбериийг үл хүлээн зөвшөөрч шинэ санхүүгийн өр төлбериийг хүлээн зөвшөөрнө.

Ангилал болон хэмжилт

Өрийн болон өмчийн хэрэгсэл нь гэрээнд заасан нөхцөлүүдийн гол мөн чанарт үндэслэн санхүүгийн өр төлбөр эсвэл өмчөөр ангилагдана.

Санхүүгийн өр төлбөрүүд нь ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр (ААБҮЦ) илэрхийлэгдсэн болон бусад санхүүгийн өр төлбөр гэж ангилагдана. Бусад санхүүгийн өр төлбериийг хорогдуулсан өргөөр хэмжинэ.

Хэрэв санхүүгийн өр төлбериийг худалдах зорилгоор болон гэрээний үүргээс бусад зорилгоор эзэмшиж байгаа тохиолдолд ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилна. Тус ангиллын санхүүгийн өр төлбериийг бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд үүссэн бодит үнэ цэний олз, гарзыг Орлогын дэлгэрэнгүй тайланд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбериийг дараах тохиолдолд худалдах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр гэж ангилна:

- Богино хугацаанд дахин худалдах зорилгоор олж эзэмшсэн;
- Анх хүлээн зөвшөөрөлтийн үед өр төлбөр нь богино хугацаанд ашиг олох зорилгоор эзэмшиж буй багцын хэсэг гэж тодорхойлогдсон; болон
- Хэйджийн хэрэглүүр хэлбэрээр эзэмшээгүй дерватив санхүүгийн хэрэгсэл.

Бусад санхүүгийн өр төлбөр нь анх бодит үнэ цэнээс арилжааны зардлыг хассан цэвэр дүнгээр хэмжигдэх ба дараа үеүдэд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өргөөр хэмжигдэнэ. Хүүгийн зардал нь орлогын дэлгэрэнгүй тайланд санхүүгийн зардлаар тусгагдана.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

3.4.5 Санхүүгийн өр төлбөр (Үргэлжлэл)

Компанид тайлагналын өдрөөр худалдах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр байгаагүй ба хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өр төлбөр зэрэг хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн өр төлбөр оршин байсан.

Уг санхүүгийн хэрэгслүүд нь богино хугацаатай болон үр ашигт хүү нь нэрлэсэн хүүгээс материаллаг зөрүүгүй тохиолдолд хорогдуулсан өртөг нь нэрлэсэн дүнтэй тэнцүү байна.

Санхүүгийн хэрэгслүүдийг хооронд нь хаах

Санхүүгийн хөрөнгө өр төлбөрүүдийг зөвхөн тэдгээрийг цэвэр дүнгээр хаах эсвэл нэгэн зэрэг барагдуулах хууль ёсны эрхтэй тохиолдолд Санхүүгийн байдлын тайланд хөрөнгө өр төлбөрүүдийг хааж цэвэр дүнгээр харуулна. Тайлагналын өдрөөр Компанид цэвэршүүлж хаасан санхүүгийн хөрөнгө, өр төлбөр байгаагүй.

3.4.6 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгүүд

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгүүд нь гар дээрх бэлэн мөнгө, банкны харилцах дахь мөнгө болон 3 сар буюу түүнээс бага хугацаатайгаар хийсэн хөрөнгө оруулалтууд, мөнгөнд хөрвөхөд бэлэн байгаа санхүүгийн хэрэгслүүдээс бүрдэнэ.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь тайлагналын өдрөөрх гадаад валютын ханшаар илэрхийлэгдэн бодит үнэ цэнээр хэмжигддэг.

3.4.7 Хувьцаат капитал

Энгийн хувьцаа

Энгийн хувьцаа нь өмчөөр ангилагддаг. Компаниас гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг (татварыг) хассан дүнгээр хэмжиж өмчийн хэсэгт бүртгэдэг.

Заавал буцаан худалдан авах нөхцөлтэй давуу эрхтэй хувьцааг өр төлбөрөөр ангилан бүртгэнэ.

3.4.8 Холбоотой талууд

Компани нь өөр аж ахуйн нэгжийн санхүүгийн болон удирдлагын шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх, эсвэл хяналт тавих эрхтэй бол холбоотой талууд болно. Хэрвээ компанийн санхүүгийн болон удирдлагын шийдвэр гаргалтад хувь хүн эсвэл өөр аж ахуйн нэгж шууд ба шууд бусаар нөлөө үзүүлдэг,

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

3.4.8 Холбоотой талууд (Үргэлжлэл)

Эсвэл хяналт тавьдаг бол мөн холбоотой талууд гэж тодорхойлдог. Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад компаниуд байж болно.

Компанийн шууд болон эцсийн хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн гэр бүлийн ойр дотнын гишүүд; болон гол хувьцаа эзэмшигчийн хяналтад байдаг эсвэл тэдгээрийн мэдэгдэхүйц нөлөөтэй аж ахуйн нэгжүүд нь мөн холбоотой талууд болно.

Холбоотой талуудын хооронд ажил гүйлгээ гарсан эсэхээс үл хамааран тэдгээрийн хоорондын харилцааг тодруулах ёстой. Холбоотой талуудын ажил гүйлгээний тодруулгад дараах зүйлсийг тодруулна.

- Худалдааны болон бусад авлага/өглөг;
- Борлуулалт/худалдан авалт; болон
- Бусад.

Компани нь санхүүгийн тайланд холбоотой талуудын ажил гүйлгээний нөлөөллийг тусад нь харуулах шаардлагатайгаас бусад тохиолдолд ижил үзүүлэлтүүдийг нийтэд нь тодруулж болно.

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Компани нь санхүүгийн хэрэгслүүдээс үүдэлтэй дараах эрсдэлүүдэд өртөж болно:

1. Зах зээлийн эрсдэл
2. Хөрвөх чадварын эрсдэл
3. Зээлийн эрсдэл

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүнд хяналт тавих чиглэлээр эцсийн хариуцлагыг хүлээндэг. Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн үйл ажиллагааг удирдах, хяналт тавих чиг үүргийн хүрээнд “Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай журам” -ыг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Компанийн эрсдэлд өртөж болзошгүй санхүүгийн хэрэгслүүд нь банкин дахь харилцах, зээлийн багц, бусад авлага болон өглөгүүд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өр төлбөр зэрэг юм.

4.1 Зах зээлийн эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн болон ирээдүйн мөнгөн урсгал зах зээл дээрх зээлийн хүүгийн өөрчлөлтөөс шалтгаалж

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оныг 12 сарын 31-нээр тасалбар болгосон

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

4.1 Зах зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

хэлбэлзэх эрсдэл юм. Тайлагналын өдрөөр Компанийн тогтмол болон хувьсах хүйтэй санхүүгийн хэрэгслүүд нь дараах байдалтай байсан.

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Тогтмол хүйтэй хэрэгслүүд:		
Зээлийн багц	5,064,259	9,275,254
Нийт		
Санхүүгийн өр төлбөр:		
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өр төлбөр	5,000,000	10,000,000
Нийт		

Бүх тогтмол хүйтэй санхүүгийн хэрэгслүүд нь хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хэрэгслүүд.

Тайлагналын өдрөөр Компанийн ашигладаг тогтмол хүйтэй санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн түвшин 16.8 - 34.8 хувийн хооронд байсан.

Тогтмол хүүгийн түвшин 10 хувь өсөхөд (буурахад) ашиг алдагдалд үзүүлэх нөлөө тайлант хугацаанд 259,029 (2022: 477,972) мянган төгрөг, өмчид үзүүлэх нөлөө 233,126 (2022: 430,174) мянган төгрөг байна.

4.2 Хөрвөх чадварын эрсдэл

Компани нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өр төлбөрийн үүргийн биелэлттэй холбоотой үүргийг хөрөнгө оруулагчдын өмнө хүлээдэг бөгөөд гэрээний үүргээ биелүүлэхэд шаардлагатай санхүүгийн хэрэгцээг биелүүлэх чадваргүй болж болзошгүй эрсдэлийг хөрвөх чадварын эрсдэл гэнэ.

Компани нь тус үүргийн гүйцэтгэлийн биелэлтийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авсан зээлийн багцын эргэн төлөлтөөс бий болох мөнгөн урсгалаар хангуулах ба Хөрөнгө Итгэмжлэн Удирдагч нь хөрөнгийн багцын хүрэлцээтэй байдал, эргэн төлөлт, мөнгөн урсгалд хяналт тавьж хөрөнгийн багцыг солих, нэмэгдүүлэх, Анхны үүрэг гүйцэтгэгчид буцаан худалдах замаар удирдана.

Дараах хүснэгтэд Компанийн санхүүгийн өр төлбөрүүдийн гэрээний дагуух хүү болон үндсэн төлбөр төлөлтийн хорогдуулаагүй мөнгөн урсгалыг харуулав.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

4.2 Хөрөх чадварын эрсдэл (Үргэлжлэл)

	Нийт дансны үнэ	Гэрээний мөнгөн урсгал	<3 сар	3-6 сар	6 сар-1 жил	1-3 жил
2023 оны 12 сарын 31- нээр	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өр төлбөр	5,000,000	5,875,000	218,750	218,750	5,437,500	-
Нийт	5,000,000	5,875,000	218,750	218,750	5,437,500	-

	Нийт дансны үнэ	Гэрээний мөнгөн урсгал	<3 сар	3-6 сар	6 сар-1 жил	1-3 жил
2022 оны 12 сарын 31- нээр	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өр төлбөр	10,000,000	12,625,000	437,500	437,500	5,875,000	5,875,000
Нийт	10,000,000	12,625,000	437,500	437,500	5,875,000	5,875,000

4.3 Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах
гэрээний дагуу шилжүүлэн авсан зээлийн багц, бусад авлагын, банканд байршуулсан
харилцах зэргээс үүснэ.

Зээлийн багц

Зээлийн багцын эргэн телелтэес бий болох мөнгөн урсгалыг хөрөнгөөр
баталгаажсан үнэт цаасны үүргийн гүйцэтгэлийг хангуулахад зарцуулах бөгөөд
зээлийн багцын хүрэлцээтэй байдал, зээлийн багцаас бий болох мөнгөн урсгалын
удирдлага, зээлийн багцын чанар зэрэгт Хөрөнгө Итгэмжлэн Удирдагч хяналт тавьж
ажилладаг. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд "Хөрөнгийн багцад өөрчлөлт
оруулах журам"-ын дагуу хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна.

Үүнд:

Багцын хөрөнгийг солих

Хэрэв дор дурдсан нөхцөлүүдийн аль нэг нь үүссэн тохиолдолд Хөрөнгө Итгэмжлэн
Удирдагч нь хөрөнгийн багц дахь зээл нь шаардлага хангахгүй гэж үзэн Анхны үүрэг
гүйцэтгүүлэгчид буцаан шилжүүлж өөр зээлээр солино.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

4.3 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

- Багц дахь хөрөнгө нь санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг хангахгүй болсон, мөн тус шалгуур үзүүлэлттэй холбоотой "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсэн;
- Зээлдэгчийн хүсэлтээр зээлийн гэрээнд орсон өөрчлөлт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өр төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах нөхцөлд нөлөөлөхүйц гэж үзсэн;
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа 90-ээс дээш хоног хэтэрсэн

Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэх

Хэрэв дор дурдсан нөхцөлүүдийн аль нэг нь үүссэн тохиолдолд хөрөнгийн багцыг нэмэгдүүлнэ.

- Хөрөнгийн багцын эргэн төлөлтөөс бий болох мөнгөн урсгал нь үнэт цаасны үүргийн гүйцэтгэлийг хангахад хүрэлцэхгүй болсон;
- Компани нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд нийцүүлэн үнэт цаас эзэмшигчдэд төлөх үндсэн болон хүүгийн төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах

Хэрэв дор дурдсан нөхцөлүүдийн аль нэг нь үүссэн тохиолдолд Компани хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана.

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь шаардлага хангахгүй хөрөнгүүдийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг Компанид гарган өгөх боломжгүй, эсвэл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд

Компани нь зээлийн багцын эрсдэл болон хүлээгдэж буй гарзыг тодорхойлоходоо Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан "Эрсдэлийн удирдлагын, дотоод хяналтын

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

4.3 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

журам"-ын дагуу зээлийн хугацаа хэтрэлтийн үзүүлэлтүүдэд үндэслэн ангилж , эрсдэлийн санг дараах байдаар байгуулдаг.

Ангилал	Эрсдэлийн сангийн хувь
Хэвийн (30 хүртэлх хоногоор хугацаа хэтэрсэн)	0%
Анхаарал хандуулах (31-90 хүртэл хоногоор хугацаа хэтэрсэн)	5%
Хэвийн бус (91-180 хүртэл хоногоор хугацаа хэтэрсэн)	25%
Эргэлзээтэй (181-360 хүртэл хоногоор хугацаа хэтэрсэн)	50%
Муу (361-ээс дээш хоног үндсэн төлбөр, хүүгийн төлбөр хийгдээгүй)	100%

Банканд байршуулсан харилцах

Банканд байршуулсан харилцах дансны хувьд Худалдаа Хөгжлийн банк дахь мөнгөнөөс бүрдэх бөгөөд тус банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээ тайлагналын өдрийн байдаар дараах байдалтай байна:

	Үнэлгээний байгууллага	Зээлжих зэрэглэл
Худалдаа хөгжлийн банк	Moody's	B(Тогтвортой) ¹
Голомт банк	S&P Global	B(Тогтвортой) ²

Тайлант жилүүдийн эцэс дэх зээлийн багцыг хугацаа хэтрэлтийн үзүүлэлтээр ангилан харуулбал дараах байдалтай байна:

	Хэвийн	1-30 хоног хэтэрсэн	31-90 хоног хэтэрсэн	91-180 хоног хэтэрсэн	Нийт
2023 оны 12 сарын 31- нээр	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Зээлийн багц	4,911,655	94,083	58,521	-	5,064,259
Нийт	4,911,655	94,083	58,521	-	5,064,259

¹ 2021 оны 03 сарын 24-ний өдрийн үнэлгээ

² 2023 оны 06 сарын 26-ны өдрийн үнэлгээ



НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

4.3 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Хэвийн 2022 оны 12 сарын 31- нээр	1-30 хоног хэтэрсэн мян.төг	31-90 хоног хэтэрсэн мян.төг	91-180 хоног хэтэрсэн мян.төг	Нийт
Зээлийн багц	8,715,730	299,509	238,101	21,914 9,275,254
Нийт	8,715,730	299,509	238,101	21,914 9,275,254

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгө

Тайлант хугацаанд хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хугацаа хэтрэлттэй зээлээс үүсэх хүлээгдэж буй гарзын дүн материаллаг бус байсан. Иймд үнэ цэний бууралтын алдагдал хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

4.4 Бодит үнэ цэний тооцоолол

Бодит үнэ цэний тооцоолол нь зах зээлийн боломжит мэдээлэл эсвэл үнэлгээний техникуудийг ашиглан хийгдэнэ.

Дерватив биш санхүүгийн өр төлбөрүүдийн бодит үнэ цэнийг Компани хэмжилтийн едрөөр зах зээлд оролцогчдын хооронд дэс дугаартай ажил гүйлгээний оронд шилжүүлэх төлбөрийн дүнгээр тодорхойлдог. Бодит үнэ цэнийг тогтооход хэрвээ зах зээлийн үнэ тодорхойлогдохуйц байвал түүнийг ашиглана, үгүй бол үнэлгээний техникийг ашиглана. Компани санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг тогтоохдоо ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг ижил шинж чанартай санхүүгийн хэрэгслийн өгөөжийн түвшинг ашиглан дискаунтчилна.

Санхүүгийн хөрөнгө өр төлбөрийн бодит үнэ цэний тооцоололд ашигласан хүүгийн түвшин дараах байдалтай байна.

	2023	2022
	%	%
Санхүүгийн хөрөнгүүд		
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгүүд	16.8-34.8	16.8 - 34.8
Санхүүгийн өр төлбөрүүд		
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөрүүд	17.5	17.5

Компанийн үйл ажиллагааны цикл нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж, Аххны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авсан зээлийн багцаар тус үнэт цаасны

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

4.3 Бодит үнэ цэний тооцоолол (Үргэлжлэл)

Үүргийн гүйцэтгэлийг хангуулах юм. Үр ашигт хүү болон нэрлэсэн хүүгийн түвшин ашиглаж тооцсон зээлийн багцын дансны үнэ нь Компанийн үйл ажиллагааны нэг циклийн хүрээнд материаллаг зөрүү үүсгэхгүй учир тус санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг нэрлэсэн хүүгийн түвшин ашиглаж хэмждэг.

Харин хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөрийн хувьд тайлант оны эцэст Монголын Хөрөнгийн Биржид ижил шинж чанартай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь Компанийн гаргасан үнэт цаасны нэрлэсэн хүүгийн түвшинтэй ижил буюу 17.5 хувийн хүйтэй гарч, бүртгэгдсэн байна. Иймд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өр төлбөрийн бодит үнэ цэн болон нэрлэсэн үнэ тэнцүү байна.

Компанийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэний хэмжилтэд ажиглагдахуйц өгөгдлийг аль болох их хэмжээгээр хэрэглэдэг. Бодит үнэ цэний хэмжилтэд хэрэглэгдэх өгөгдлийг ажиглагдахуйц байдлаар нь гурван түвшинд ангилдаг.

Бодит үнэ цэний шатлал:

Түвшин 1: Идэвхтэй зах зээл дэх тогтоогдсон хөрөнгө, өр төлбөрийн үнэ (тохируулга хийгдээгүй)

Түвшин 2: Түвшин 1-ээс бусад ажиглагдахуйц шууд ба шууд бус өгөгдөл ашигласан

Түвшин 3: Үл ажиглагдахуйц өгөгдөл ашигласан (зах зээлийн бус мэдээлэл)

Санхүүгийн байдлын тайлан дахь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн дансны ба бодит үнэ цэнүүд нь тайлант өдрөөр дараах байдалтай байна:

	Түвшин 1 мян.төг	Түвшин 2 мян.төг	Түвшин 3 мян.төг	Нийт мян.төг
2023 оны 12 сарын 31-нээр				
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгүүд				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,305	-	-	9,305
Бусад авлага	-	425,124	-	425,124
Зээлийн багц	-	5,064,259	-	5,064,259
Нийт	9,305	5,489,383	-	5,498,688
 Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өрүүд				
Санхүүгийн өр төлбөр	-	5,000,000	-	5,000,000
Нийт	-	5,000,000	-	5,000,000

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгасон

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

4.3 Бодит үнэ цэний тооцоолол (Үргэлжлэл)

2022 оны 12 сарын 31-нээр Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгүүд	Түвшин 1 мян.төг	Түвшин 2 мян.төг	Түвшин 3 мян.төг	Нийт мян.төг
	38,112	-	-	38,112
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	534,980	-	534,980
Бусад авлага	-	9,275,254	-	9,275,254
Нийт	38,112	9,810,234	-	9,848,346

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өрүүд

Санхүүгийн өр төлбөр	-	10,000,000	-	10,000,000
Нийт	-	10,000,000	-	10,000,000

5. Нягтлан бодох бүртгэлийн гол тооцоолол болон төсөөлөл

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал, болзошгүй хөрөнгө, өр төлбөрүүдэд болон тэдгээрийн тодруулгад нөлөөлөх тооцоолол болон төсөөллүүдийг хийх шаардлагатай болдог. Боломжит мэдээллүүдийн хэрэглээ, ашигласан шийдлүүд нь тооцооллыг гаргаж ирэх явцад уламжлалт эрсдэлтэй ба тухайн нөхцөл байдалд ашигласан өнгөрсөн туршлагууд болон ирээдүйн үйл явдлын хүлээлтүүдийг үндэслэлтэй гэж үзсэн. Тухайн тооцооллын бодит үр дүн нь ирээдүйд хийсэн тооцооллоос ялгаатай байж болно.

Санхүүгийн тайланд ашиглагдсан мэргэжлийн шийдэл, тооцооллуудын төсөөллүүд нь үечлэн хянагдах бөгөөд ашигласан төсөөлөл болон шийдвэр гаргах мэдээлэлд нөлөөлөх хүчин зүйлүүд өөрчлөгдсөн тохиолдолд тооцоолол, төсөөллүүд нь мен өөрчлөгднө. Тооцоололд гарсан аливаа өөрчлөлт нь ирээдүйд ашиглагдах аргын дагуу бүртгэгдэнэ.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

6. Хүүгийн орлого

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Хүүгийн орлого /Тод.13/	2,714,243	646,908
Нэмэгдүүлсэн хүүгийн орлого	5,371	1,782
Харилцах ба хадгаламжийн хүүгийн орлого	130,952	-
	2,850,566	648,690

Компани нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэн авсан хөрөнгийн багц дахь зээлүүдээс тайлант хугацаанд 2,719,614 (2022: 648,690) мянган төгрөгийн хүүгийн орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна /Тодруулга 13/. Харилцах данс болон хадгаламжийн данснаас 130,952 мянган төгрөгийн хүүгийн орлого бүртгэсэн байна /Тодруулга 14/.

7. Хүүгийн зардал

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Хүүгийн зардал /Тод.18/	1,579,379	354,795
	1,579,379	354,795

8. Үйл ажиллагааны зардал

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Мэргэжлийн үйлчилгээний зардал	516,354	481,510
Маркетинг, зар сурталчилгааны зардал	-	12,457
Банкны үйлчилгээний шимтгэлийн зардал	80	83
	516,434	494,050

Мэргэжлийн үйлчилгээний зардал нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудад телсэн мэргэжлийн үйлчилгээний зардлаас бүрдэнэ.

9. Бусад зардал

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Бусад зардал	40	42,338
	40	42,338

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЭГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

10. Орлогын татвар

Компани тайлант жилүүдэд хүчин төгөлдөр мөрдөж байсан хуулийн дагуу 6 тэрбум төгрөг хүртэлх ашгаас 10%-ийн орлогын албан татвар, түүнээс дээш ашигт 25%-ийн орлогын албан татвар төлдөг. Тайлант жилийн татварын зардлыг Орлогын дэлгэрэнгүй тайлангийн ашиг алдагдалд хэрхэн зохицуулсныг доор харуулав:

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Тайлант жилийн татвар:		
Татварын өмнөх ашиг (алдагдал)-д ногдох татвар	754,713	(242,493)
Тусгайлсан хувь хэмжээтэй орлогын нөлөөлөл	(130,952)	-
Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдох ашиг (алдагдал)	623,761	(242,493)
Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татвар	62,376	-
Тусгайлсан хувь хэмжээгээр ногдуулсан татвар	13,095	-
Тайлант жилийн татварын зардал	75,471	-

11. Бусад авлага

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Бусад авлага /Тод.20/		
Татвар, НДШ-ийн авлага	422,910	534,980
	2,214	-
	425,124	534,980

Компани нь тайлант хугацаанд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх гэрээ"-г байгуулсан бөгөөд тус гэрээний хүрээнд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багц дахь зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлбөрийг цуглуулж Компанид шилжүүлэх үүрэг хүлээсэн байна. Тус гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь тухайн сард цугларсан зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг дараа сарын 10-ны өдрийн дотор Компанид шилжүүлэх нөхцөлтэй ба үүнтэй холбоотой тайлант хугацааны эцэст 422,910 (2022: 534,980) мянган төгрөгийн бусад авлага /Тодруулга 20/, 149,741 (2022: 264,956) мянган төгрөгийн хүүгийн авлагы /Тодруулга 12/ хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

12. Хүүгийн авлага

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Хүүгийн авлага /Тод.20/	149,741	264,956
	149,741	264,956

13. Санхүүгийн хөрөнгө**Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгө**

	2023.12.31	2022.12.31
	Эргэлтийн	Эргэлтийн
	бус	бус
	мян.төг	мян.төг
Зээлийн багц	5,064,259	-
	5,064,259	-
	5,064,259	-
	9,275,254	-
	9,275,254	-

Санхүүгийн хөрөнгө нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу шилжүүлэн авсан зээлийн багцаас бүрдэх бөгөөд эдгээр зээлүүд нь 100 хувь автомашин барьцаалсан зээлүүд байна.

Компанийн үйл ажиллагааны цикл нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авсан зээлийн багцын эргэн төлөлтөөс бий болох мөнгөн урсгалаар тус үнэт цаасны үүргийн гүйцэтгэлийг хангуулах юм.

Хэдийгээр хөрөнгийн багц дахь зээлүүд нь 72 сар хүртэлх хугацаатай байх боловч эдгээр зээлүүд нь Компанийн үйл ажиллагааны нэг циклийн дотор төлөгдөх зорилготой, мөн хугацаанаас өмнө хөрөнгийн багцаас хасаж болох нөхцөлтэй учир эргэлтийн хөрөнгөөр ангилагдан бүртгэгддэг. Иймд үр ашигт хүү болон нэрлэсэн хүүгийн түвшин ашиглаж тооцсон зээлийн багцын дансны үнэ, хүүгийн орлого нь Компанийн үйл ажиллагааны нэг циклийн хүрээнд материаллаг зөрүү үүсгэхгүй учир санхүүгийн хөрөнгүүдийн хорогдуулсан өртгийг нэрлэсэн хүүгийн түвшин ашиглаж хэмждэг. Тайлант хугацаанд хөрөнгийн багц дахь зээлийн хүүгийн түвшин 16.8 - 34.8 хувийн хооронд байсан ба хөрөнгийн багц нь нийт 358 (2022: 564) зээлийн гэрээнээс бүрдэж байна. Тус зээлийн багцтай холбоотой тайлант хугацаанд 2,719,614 (2022: 648,690) мянган төгрөгийн хүүгийн орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна /Тодруулга 6/.

Компани нь зээлийн багцаас бий болох мөнгөн орлогыг Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээний төлбөр, Хөрөнгө Итгэмжлэн Удирдах үйлчилгээний төлбөрийг төлх,

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ**Санхүүгийн тайлангийн тодруулга****2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон****13. Санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)**

хөрөнгийн багцын өгөөжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулахын тулд хөрөнгийн багц нэмж худалдан авах зэргээр зарцуулж байна. Мөн тайлагналын дараа буюу 2024 онд үнэт цаасны эхний улирлын хүүгийн төлбөрийг төлсөн байна /Тодруулга 21/. Тайлант хугацааны зээлийн багцын хөдөлгөөн дараах байдалтай байна:

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Анх худалдан авсан багц	9,275,254	9,983,639
Төлөгдсөн үндсэн төлбөр	(7,312,349)	(1,274,209)
Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаасан	(1,879,504)	(63,662)
Нэмж худалдан авсан багц	4,980,858	629,486
Эцсийн үлдэгдэл	5,064,259	9,275,254

14. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Банкны харилцах дахь мөнгө	9,305	38,112
	9,305	38,112

Тайлант онд банкин дахь харилцах данс болон хадгаламжийн дансанд 130,952 (2022:0) мянган төгрөгийн хүүгийн орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна /Тодруулга 6/.

15. Хувьцаат капитал

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
01 сарын 01	1,000	-
Нэмэгдсэн	-	1,000
12 сарын 31	1,000	1,000
Эргэлтэд байгаа хувьцааны тоо ширхэг	100	100
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ	10,000	10,000

Компанийн энгийн хувьцааг Монгол Улсын хуулийн этгээд Нөмөр Кредит ББСБ ХХК 100 хувь эзэмшдэг. Бүх гаргасан хувьцааны төлбөр бүрэн төлөгдсөн бөгөөд нэг энгийн хувьцаа нь нэг саналын эрхтэй.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ**Санхүүгийн тайлангийн тодруулга****2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон****16. Хуримтлагдсан ашиг (алдагдал)**

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
01 сарын 01	(242,493)	-
Тайлант үеийн ашиг (алдагдал)	679,242	(242,493)
12 сарын 31	(436,749)	(242,493)

17. Санхүүгийн өр төлбөр

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Эргэлтийн бус:		
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өр төлбөр	-	5,000,000
Эргэлтийн:		
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өр төлбөр	5,000,000	5,000,000
Нийт	5,000,000	10,000,000

Компани нь 2022 оны 10-р сард 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100,000 ширхэг, нийт 10,000,000 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 24 сарын хугацаатай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй хүрээнд санал болгож, худалдсан.

Тус үнэт цаас нь жилийн 17.5 хувийн хүүтэй ба үндсэн төлбөрийг 12 сар тутам, хүүгийн төлбөрийг улирал тутам төлөх нөхцөлтэй. Компани үндсэн төлбөрийн 12 сарын дотор төлөгдөх хэсгийг эргэлтийн өр төлбөреөр, түүнээс хойш төлөгдөх хэсгийг эргэлтийн бус өр төлбөреөр ангилан бүртгэсэн. Үнэт цаас нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу шилжүүлэн авсан хөрөнгийн багц дахь зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс бий болох мөнгөн урсгалаар төлөгдөнө.

Компани нь тайлант онд тус үнэт цаастай холбоотой 1,579,379 (2022: 354,795) мянган төгрөгийн хүүгийн зардал хүлээн зөвшөөрсөн /Тодруулга. 7, 18/.

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

18. Хүүгийн өглөг

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Хүүгийн өглөг /Тод. 17/	177,397	354,795
	177,397	354,795

19. Бусад өглөг

	2023.12.31	2022.12.31
	мян.төг	мян.төг
Бусад өглөг		
Бусад өглөг	16,000	-
	16,000	-
Татвар, НДШ-н өглөг		
ДАНОАТ-ын өглөг	17,283	-
	17,283	-

20. Холбоотой талууд

Дараах хүснэгтэд Компанийн гол холбоотой талуудын мэдээллийг харуулав:

Нэр	Харьяалал/Бүрт-гэлтэй улс	Харилцан хамаарал
Немер Кредит ББСБ ХХК	Монгол Улс	Толгой компани
Новатек интернэйшнл ХХК	Монгол Улс	Толгой компанийн хувьцаа эзэмшигч
Кемекс ХХК	Монгол Улс	Толгой компанийн хувьцаа эзэмшигч
Эрчим электрик ХХК	Монгол Улс	Толгой компанийн хувьцаа эзэмшигч
Намир ХХК	Монгол Улс	Нэг эцсийн өмчлөгчтэй
Мехлопат ХХК	Монгол Улс	Толгой компанийн хувьцаа эзэмшигч нь тус компанийн эцсийн өмчлөгч
Бавария Моторс ХХК	Монгол Улс	Нэг эцсийн өмчлөгчтэй
Дриллэкс ХХК	Монгол Улс	Нэг эцсийн өмчлөгчтэй

НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЭК ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

Санхүүгийн тайлангийн тодруулга

2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон

20. Холбоотой Талууд (Үргэлжлэл)

Дараах хүснэгтэд холбоотой талуудтай тайлант жилд хийсэн нийт ажил гүйлгээний дунгүүд болон үлдэгдэл дунгүүдийг толилуулав:

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр	Бусад авлага	Хүүгийн авлага	Худалдан авалт, үйлчилгээ	Ажил гүйлгээний шинж чанар
Холбоотой талууд	мян.төг	мян.төг	мян.төг	
Номер Кредит ББСБ ХХК	422,910	149,741	5,283,002	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой хөрөнгийн багц худалдан авах, төлбөр цуглуулах үйлчилгээ
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр	Бусад авлага	Хүүгийн авлага	Худалдан авалт, үйлчилгээ	Ажил гүйлгээний шинж чанар
Холбоотой талууд	мян.төг	мян.төг	мян.төг	
Номер Кредит ББСБ ХХК	534,980	264,956	10,707,666	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотой хөрөнгийн багц худалдан авах, төлбөр цуглуулах үйлчилгээ

21. Тайлагналын Дараах Үйл Явдлууд

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлан
тарснаас хойш дор дурдсанаас бусдаар санхүүгийн тайланд тодруулахуйц үйл явдал
тараалуй байна.

- Компани нь 2024 оны 01-р сард эхний улирлын үнэт цаасны хүүгийн төлбөр болох 210,415 мянган төгрөгийг үнэт цаас эзэмшигчдэд төлж барагдуулсан байна.
- 2023 оноос аудитын тайлан гарах хүртэл зээлийн хөрөнгийн багцад дараах
өөрчлөлт хийгдсэн байна:

Хөрөнгийн багц нэмэгдсэн: Компани нь нийт 1,408,131 мянган төгрөгийн үлдэгдэл
бухий зээлүүдийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдан авч хөрөнгийн багцыг
нэмэгдүүлсэн байна.